ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/016/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Наранчимэг<br>Утас:261665 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер:В.Эрдэнэцог<br>Утас:261885 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.mn<br>Аудитор:Ж.Бямбацогт<br>Утас261628 Цахим хаяг:byambatsogtj@audit.gov.mb<br>“Ирмүүн хантайшир аудит”.ХХК-ийн захирал: Д.Бямбацэрэн<br>Утас:77550809 Цахим хаяг: irmuunkhantaishir@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/750
танай ____________-ны №_____________-т

ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 758,800.0 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулаагүй;
- Тайлант хугацаанд худалдан авсан 200,168.2 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг 13 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулан нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй;
- Цалин хөлс, ээлжийн амралтыг 70,827.1 мянган төгрөгөөр давхардуулан олгосон;

зэрэг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2, 32 дугаар зүйлийн 32.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 99.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 16 дугаар зүйлийн 16.5.5 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын санаас авах үйлчилгээний авлага 19,534,879.9 мянган төгрөг, байгууллагад төлөх эмийн өглөг нь 9,052,172.2 мянган төгрөг байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас 136,651,2 мянган төгрөгийн бараа материал, 1,682,358.3 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, 758,800.0 мянган төгрөгийн их засварын ажил, нийт 2,578,809.5 мянган хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2024 оны үйл ажиллагааны чиглэлээр 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг төлөвлөснөөс 36 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 4 арга хэмжээг хэрэгжүүлэх түвшинд, нисдэг тэрэгний талбайг стандартын дагуу өргөтгөх 1 арга хэмжээ хийгдээгүй, хэрэгжилтийг 91.8 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-76.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,626,448,249.35** | **27,161,872,476.85** |
| 31 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **146,114,439.23** | **1,903,401,649.63** |
| 31110 | Төгрөг | 1,639,905.26 | 270,685.26 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 144,474,534.97 | 1,903,130,964.37 |
| 33 | АВЛАГА | **29,928,199,300.0** | **19,534,879,878.68** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 29,796,056,767.00 | 19,434,792,966.68 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 129,642,533.00 | 100,086,912.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,500,000.00 | - |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **4,552,134,510.12** | **5,723,590,948.54** |
| 35110 | Өндөр өртөгт мэс заслын хэрэгсэл | 1,263,074,893.02 | 1,314,011,910.96 |
| 35130 | Эм боох материал | 810,862,615.36 | 834,016,408.99 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 360,620.00 | 600,080.00 |
| 35411 | Улсын мэдээллийн маягт | 1,418,400.00 | - |
| 35421 | Аж ахуйн материал | 441,399,336.00 | 545,744,689.00 |
| 35420 | Цэвэрлэгээний материал | 550,000.00 | - |
| 35430 | Эмнэлэгийн жижиг багаж хэрэгсэл | 1,718,489,140.47 | 2,597,607,274.29 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 16,703,286.89 | 28,480,812.89 |
| 35450 | Барилгын засварын материал | 33,279,100.00 | 69,009,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 11,526,745.03 | 12,536,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 254,470,373.35 | 321,584,673.35 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,337,818,733.87** | **39,212,867,042.31** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **40,337,818,733.87** | **39,212,867,042.31** |
| 392 | Биет хөрөнгө | 39,356,756,932.25 | 38,238,158,879.73 |
| 39201 | Барилга, байгууламж | 21,799,983,101.01 | 21,799,983,101.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,776,438,468.87) | (2,172,903,667.47) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 530,892,279.00 | 1,756,213,457.87 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (150,564,466.92) | (309,993,789.57) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 28,746,326,578.08 | 30,273,065,540.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (10,584,498,425.76) | (13,929,298,144.15 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,225,455,535.54 | 1,408,185,550.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (451,288,332.26) | (602,644,695.27) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,384,900.00 | 27,384,900.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,495,767.60) | (11,833,373.52) |
| 393 | Биет бус хөрөнгө | 981,061,774.62 | 974,708,162.58 |
| 39301 | Програм хангамж | 7,025,000.00 | 7,025,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (415,800.00) | (831,600.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 987,338,720.00 | 987,338,720.00 |
| 39304 | Хасагдуулга | (12,886,145.38) | (18,823,957.42) |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **74,964,266,983.22** | **66,374,739,519.16** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **9,052,172,207.35** | **14,435,924,656.68** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9,052,172,207.35** | **14,435,924,656.68** |
| 413 | **Өглөг** | **9,052,172,207.35** | **14,435,924,656.68** |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 1,045,244,961.45 | 489,049,230.25 |
| 4136 | **Бусад өглөг** | **8,006,927,245.90** | **13,946,875,426.43** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 8,006,927,245.90 | 13,946,875,426.43 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **65,912,094,775.87** | **51,938,814,862.48** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 65,912,094,775.87 | 51,938,814,862.48 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 9,974,253,679.78 | 9,974,253,679.78 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 9,974,253,679.78 | 9,974,253,679.78 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **40,458,747,942.27** | **26,485,468,028.88** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 35,342,496,198.44 | 40,518,675,942.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 5,116,251,743.83 | (14,033,207,913.39) |
| 229 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,479,093,153.82 | 15,479,093,153.82 |
| 233 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **74,964,266,983.22** | **66,374,739,519.16** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН(I)** | **70,835,685,924.23** | **69,635,999,859.32** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,093,532,249.23** | **7,125,408,197.32** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **10,093,532,249.23** | **7,125,408,197.32** |
| 120004 | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **6,490,475,979.19** | **3,907,173,607.47** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,993,440,189.51 | 2,905,104,646.24 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,077,627,612.68 | 1,002,068,961.23 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,419,408,177.00 | 758,676,193.06 |
| 120005 | Түрээсийн орлого | 133,729,913.00 | 462,076,493.00 |
| 120006 | Газрын тосны орлого | 5,000,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | 3,039,536,824.75 | 1,701,258,072.47 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | 424,789,532.29 | 296,223,831.32 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **60,742,153,675.00** | **62,510,591,662.00** |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс** | **60,742,153,675.00** | **62,510,591,662.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 60,742,153,675.00 | 62,510,591,662.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **65,719,434,180.40** | **83,669,207,772.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **65,719,434,180.40** | **83,669,207,772.71** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **65,360,673,942.40** | **82,814,140,370.58** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | **26,195,419,588.49** | **35,459,713,144.54** |
| 210101 | Цалин | 12,523,105,620.65 | 17,657,480,544.68 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 10,787,055,429.25 | 14,105,147,905.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,154,129,579.72 | 1,387,443,265.18 |
| 210104 | Урамшуулал | 1,731,128,958.87 | 2,309,641,429.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,255,314,590.12** | **4,736,735,604.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 2,253,243,843.82 | 3,058,402,039.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 245,412,609.79 | 361,813,818.83 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 223,232,852.38 | 239,856,061.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 50,352,244.72 | 169,641,116.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 483,073,039.41 | 907,022,569.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,392,846,373.33** | **1,678,876,850.94** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 687,760,139.04 | 808,375,788.52 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 286,509,803.54 | 249,425,989.33 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 418,576,430.75 | 621,075,073.09 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,116,768,570.43** | **1,618,854,791.74** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 83,038,780.00 | 148,409,064.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 124,847,842.00 | 154,987,434.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 59,293,338.43 | 89,421,898.16 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 629,049,419.00 | 817,804,981.08 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 220,539,191.00 | 408,231,414.50 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,503,239,001.89** | **30,735,097,984.48** |
| 210501 | Эм | 24,274,798,575.89 | 28,856,464,446.28 |
| 210502 | Хоол | 1,085,138,906.00 | 1,724,295,384.02 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 143,301,520.00 | 154,338,154.18 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,486,437,038.22** | **2,470,827,076.64** |
| 210601 | Багаж хэрэгсэл | 90,425,620.00 | 165,790,820.78 |
| 210602 | Тавилга | 3,800,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 6,925,000.00 | 16,829,960.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,385,286,418.22 | 2,288,206,295.86 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **54,981,500.00** | **110,389,700.00** |
| 210701 | Гадаад томилолтын зардал | 4,086,000.00 | - |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 50,895,500.00 | 110,389,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **244,658,512.00** | **200,786,252.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 173,215,500.00 | 119,261,026.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 12,000,000.00 | 16,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 9,549,524.00 | 6,496,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 935,188.00 | 880,603.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 242,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 11,062,423.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 127,000.00 | 48,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 48,589,300.00 | 46,708,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,111,008,767.92** | **5,802,858,965.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 270,296,046.08 | 356,878,278.58 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 19,999,467.07 | 86,399,783.90 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,820,713,254.77 | 5,359,580,903.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **358,760,238.00** | **855,067,402.13** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 358,760,238.00 | 855,067,402.13 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 276,315,238.00 | 756,089,258.51 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 82,445,000.00 | 98,978,143.62 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **5,116,251,743.83** | **(14,033,207,913.39)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **-** |
| **VI** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=(III)+(IV)-(V) | **5,116,251,743.83** | **(14,033,207,913.39)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *IтөгрөгөөрI*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **52,955,216,622.68** | **77,363,349,086.79** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,156,591,964.68** | **4,491,493,624.47** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,156,591,964.68** | **4,491,493,624.47** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 4,005,476,949.19 | 4,173,717,684.87 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,073,586,919.27 | 2,883,261,846.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 931,890,029.92 | 1,290,455,838.87 |
| 120005 | Түрээсийн орлого | 146,115,015.49 | 317,775,939.60 |
| 120006 | Газрын тосны орлого | 5,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **48,798,624,658.00** | **72,871,855,462.32** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **48,798,624,658.00** | **72,871,855,462.32** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 48,798,624,658.00 | 72,871,855,462.32 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 53,464,181,899.08 | 74,795,779,937.39 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **53,464,181,899.08** | **74,795,779,937.39** |
| 210 | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **53,061,324,939.08** | **73,938,818,535.26** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **25,542,844,548.35** | **36,038,470,679.47** |
| 210101 | Үндсэн цалин | 11,343,515,913.92 | 15,770,040,232.56 |
| 210102 | Нэмэгдэл | 10,866,296,038.97 | 14,381,369,227.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,167,076,793.32 | 3,830,261,138.49 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 2,165,955,803.14 | 2,056,800,080.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **2,853,934,643.56** | **4,713,207,298.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 1,955,785,212.93 | 3,441,416,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 230,109,265.65 | 329,684,200.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 181,706,911.40 | 167,896,398.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 44,162,099.75 | 154,842,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 442,171,153.83 | 619,368,400.00 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **1,392,846,373.33** | **1,612,773,050.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 687,760,139.04 | 779,772,372.66 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 286,509,803.54 | 249,425,989.33 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 418,576,430.75 | 583,574,688.01 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,208,157,280.00** | **1,549,652,706.66** |
| 210401 | Бичиг хэрэг | 76,197,465.00 | 127,741,717.99 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 122,860,760.00 | 165,890,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 57,120,000.00 | 69,251,453.16 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 601,701,200.00 | 636,920,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 350,277,855.00 | 549,849,235.51 |
| **2105** | **Нормативт зардал** | **18,920,574,067.04** | **26,344,985,042.93** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,608,476,495.20 | 24,482,664,475.94 |
| 210502 | Хоол, хүнс | 1,009,868,253.84 | 1,587,138,036.99 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 302,229,318.00 | 275,182,530.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,559,370,733.22 | 2,803,115,177.78 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 391,201,906.00 | 1,416,537,936.78 |
| 210602 | Тавилга | 4,805,100.00 | 990,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 40,500,000.00 | 16,829,960.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,122,863,727.22 | 1,368,757,281.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **55,441,500.00** | **109,915,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 55,441,500.00 | 109,915,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **235,930,500.00** | **232,956,486.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 192,565,500.00 | 149,750,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 12,000,000.00 | 16,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,690,000.00 | 6,496,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,536,000.00 | 991,763.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 242,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 11,062,423.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 127,000.00 | 48,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 21,770,000.00 | 48,278,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **292,225,293.58** | **533,742,394.42** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 269,361,826.51 | 424,992,945.52 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,863,467.07 | 108,749,448.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **402,856,960.00** | **856,961,402.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **402,856,960.00** | **856,961,402.13** |
| 213207 | **Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж** | **317,861,960.00** | **756,089,258.51** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 84,995,000.00 | 100,872,143.62 |
| **III** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | (508,965,276.40) | 2,567,569,149.40 |
| **V** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,204,752,390.13 | 810,281,939.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,204,752,390.13 | 810,281,939.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,204,752,390.1** | **810,281,939.0** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,204,752,390.13 | 810,281,939.00 |
| **VI** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | **(1,204,752,390.13)** | **(810,281,939.00)** |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | **(1,713,717,666.53)** | **1,757,287,210.40** |
| 01 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,859,832,105.76 | 146,114,439.23 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 146,114,439.23 | 1,903,401,649.63 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| зүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **9,974,253,679.78** | **15,987,156,209.98** | **(3,595,526,594.49)** | **22,365,883,295.27** |
| Нягтлан бодох бүртгэлийн | - | - | 508,063,056.16 | 508,063,056.16 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,974,253,679.78 | 15,987,156,209.98 | (3,087,463,538.33) | 22,873,946,351.43 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 7,406,339,902.9 | 7,406,339,902.9 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **9,974,253,679.78** | **15,479,093,153.82** | **40,458,747,942.27** | **65,912,094,775.87** |
| Нягтлан бодох бүртгэл ийн бодлогын өөрчлөлт | - | - | 59,928,000.00 | 59,928,000.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **9,974,253,679.78** | **15,479,093,153.82** | **40,518,675,942.27** | **65,972,022,775.87** |
| Тайлант үеийн үр дүн /цэвэр алдагдал/ | - | - | (14,033,207,913.39) | (14,033,207,913.39) |
| 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **9,974,253,679.78** | **15,479,093,153.82** | **26,485,468,028.88** | **51,938,814,862.48** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 146,114,439.23 | (146,114,439.23) | - |
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **77,702,529,700.00** | **75,606,061,876.39** | **2,096,467,823.61** | **97.3** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **77,702,529,700.00** | **75,606,061,876.39** | **2,096,467,823.61** | **97.3** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **76,220,529,700.00** | **74,749,100,474.26** | **1,471,429,225.74** | **98.1** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 36,907,696,500.00 | 36,038,470,679.47 | 869,225,820.53 | **97.6** |
| Үндсэн цалин | 15,546,560,000.00 | 5,770,040,232.56 | (223,480,232.56) | 101.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нэмэгдэл | 15,100,945,800.00 | 14,381,369,227.69 | 719,576,572.31 | 95.2 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 4,332,000,000.00 | 3,830,261,138.49 | 501,738,861.51 | 88.4 |
| Урамшуулал | 1,928,190,700.00 | 2,056,800,080.73 | (128,609,380.73) | 106.7 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,861,798,400.00** | **4,713,207,298.00** | **148,591,102.00** | **96.9** |
| Тэтгэврийн даатгал | 3,510,410,500.00 | 3,441,416,300.00 | 68,994,200.00 | 98.0 |
| Тэтгэмжийн даатгал | 337,847,000.00 | 329,684,200.00 | 8,162,800.00 | 97.6 |
| ҮОМШӨ ний даатгал | 168,923,500.00 | 167,896,398.00 | 1,027,102.00 | 99.4 |
| Ажилгүйдлийн даатгал | 168,923,500.00 | 154,842,000.00 | 14,081,500.00 | 91.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 675,693,900.00 | 619,368,400.00 | 56,325,500.00 | 91.7 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,629,233,000.00** | **1,612,773,050.00** | **16,459,950.00** | **99.0** |
| Гэрэл цахилгаан | 712,625,000.00 | 779,772,372.66 | (67,147,372.66) | 109.4 |
| Түлш, халаалт | 385,208,000.00 | 249,425,989.33 | 135,782,010.67 | 64.8 |
| Цэвэр, бохир ус | 531,400,000.00 | 583,574,688.01 | (52,174,688.01) | 109.8 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **1,553,083,400.00** | **1,552,605,706.66** | **477,693.34** | **100.0** |
| Бичиг хэрэг | 127,999,200.00 | 127,741,718.99 | 257,482.01 | 99.8 |
| Тээвэр (шатахуун) | 182,666,000.00 | 165,890,000.00 | 16,776,000.00 | 90.8 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 81,000,000.00 | 69,251,453.16 | 11,748,546.84 | 85.5 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 639,751,000.00 | 636,920,300.00 | 2,830,700.00 | 99.6 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 521,667,200.00 | 552,802,235.51 | (31,135,035.51) | 106.0 |
| **Нормативт зардал** | **26,663,938,900.00** | **26,344,985,042.93** | **318,953,857.07** | **98.8** |
| Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,099,187,900.00 | 24,482,664,475.94 | 616,523,424.06 | 97.5 |
| Хоол, хүнс | 1,312,206,000.00 | 1,587,138,036.99 | (274,932,036.99) | 121.0 |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 252,545,000.00 | 275,182,530.00 | (22,637,530.00) | 109.0 |
| **Эд хогшил худалдан авах** | **3,635,874,300.00** | **3,610,444,116.78** | **25,430,183.22** | **99.3** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Багаж, техник, хэрэгсэл | 2,028,173,300.00 | 2,008,512,535.78 | 19,660,764.22 | 99.0 |
| Тавилга | 211,894,800.00 | 174,437,840.00 | 37,456,960.00 | 82.3 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 20,000,000.00 | 16,829,960.00 | 3,170,040.00 | 84.1 |
| Урсгал засвар | 1,375,806,200.00 | 1,410,663,781.00 | (34,857,581.00) | 102.5 |
| **Томилолт, зочны зардал** | **110,000,000.00** | **109,915,700.00** | **84,300.00** | **99.9** |
| Дотоод албан томилолт | 110,000,000.00 | 109,915,700.00 | 84,300.00 | 99.9 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **236,254,300.00** | **232,956,486.00** | **3,297,814.00** | **98.6** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 149,750,300.00 | 149,750,300.00 | - | 100.0 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 16,000,000.00 | 16,000,000.00 | - | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 7,690,000.00 | 6,496,000.00 | 1,194,000.00 | 84.5 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 1,536,000.00 | 991,763.00 | 544,237.00 | 64.6 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 500,000.00 | 330,000.00 | 170,000.00 | 66.0 |
| Газрын төлбөр | 12,000,000.00 | 11,062,423.00 | 937,577.00 | 92.2 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000.00 | 48,000.00 | 452,000.00 | 9.6 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 48,278,000.00 | 48,278,000.00 | - | 100.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **622,650,900.00** | **533,742,394.42** | **88,908,505.58** | **85.7** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 425,596,800.00 | 424,992,945.52 | 603,854.48 | 99.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 197,054,100.00 | 108,749,448.90 | 88,304,651.10 | 55.2 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,482,000,000.00** | **856,961,402.13** | **625,038,597.87** | **57.8** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусад урсгал шилжүүлэг** | **1,482,000,000.00** | **856,961,402.13** | **625,038,597.87** | **57.8** |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,367,000,000.00 | 756,089,258.51 | 610,910,741.49 | 55.3 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 115,000,000.00 | 100,872,143.62 | 14,127,856.38 | 87.7 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **77,680,314,500.00** | **77,363,349,086.79** | **316,965,413.21** | **99.6** |
| **НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **72,364,884,500.00** | **72,871,855,462.32** | **(506,970,962.32)** | **100.7** |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 72,364,884,500.00 | 72,871,855,462.32 | (506,970,962.32) | 100.7 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НААС** | **5,315,430,000.02** | **4,491,493,624.47** | **823,936,375.53** | **84.5** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,947,985,600.00 | 2,883,261,846.00 | 1,064,723,754.00 | 73.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,367,444,400.00 | 1,290,455,838.87 | 76,988,561.13 | 94.4 |
| Түрээсийн орлого | - | 317,775,939.60 | (317,775,939.60) | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 146,114,439.23 | (146,114,439.23) | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 1,903,401,649.63 | (1,903,401,649.63) | - |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **-** | **-** | **-** | **-** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **-** | **-** | **-** | **-** |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **963** | **994** | **(31)** | **103.2** |
| Удирдах ажилтан | 1 | 5 | (4) | 500.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 771 | 726 | 45 | 94.2 |
| Үйлчлэх ажилтан | 191 | 263 | (72) | 137.7 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,044,410.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 70,827.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 966,868.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 6,714.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | 2023 оны амралтын нөхөн олговрыг урамшууллын зардлаас төсөв хэтрүүлэн нэмэгдэл цалин хэлбэрээр олгосон | 1 | 25,200.2 | 1 | 25,200.2 | | | | | | | | |
| 2 | Ажилтны ээлжийн амралтыг цалинтай давхардуулан олгосон | 1 | 45,626.9 | 1 | 45,626.9 | | | | | | | | |
| 3 | 2023 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч хариуцлагатай ажилласан ажилтнуудад олгодог балансын урамшуулалт цалинг захирал болон албаны дарга зэрэг албан тушаалтанд олгосон | 1 | 7,900.0 | | | 1 | 7,900.0 | | | | | | |
| 4 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй тавилга эд хогшлын шууд гэрээ байгуулан хийж нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийсэн | 1 | 200,168.2 | | | 1 | 200,168.2 | | | | | | |
| 5 | Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засварын ажлыг капиталжуулаагүй урсгал зардлаар бүртгэсэн | 1 | 758,800.0 | | | 1 | 758,800.0 | | | | | | |
| 6 | Байгууллагын худалдан авах үйл ажиллагааны бичиг баримт, холбогдох гэрээний дугаарлалт, давхардсан гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөөгүй, гэрээний | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийн байдалд хяналт тавьж ажиллаагүй бичиг баримтын эмх цэгц хангалтгүй | | | | | | | | | | | | |
| 7 | ТӨБЗГ болон аж ахуйн нэгж компанитай байгуулсан түрээсийн гэрээнд гэрэл, цахилгаан, дулаан усны зардлыг түрээслэгч төлөхөөр тусгасан байхад аж ахуйн нэгж байгууллагаас тооцоолон аваагүй | 1 | 6,714.7 | | | | | 1 | 6,714.7 | | | | |
| | Дүн | **7** | **1,044,410.0** | **2** | **70,827.1** | **3** | **966,868.2** | **2** | **6,714.7** | | | | |

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан ба аудитаар нийцлийн аудиттай холбоотой ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй болно.